



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2018.04.04 № 1/486
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай яамнаас зарласан №УУХҮЯ/201801009 дугаартай “Уул уурхай хүнд, үйлдвэрийн яамны эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зөвлөх үйлчилгээ”-ний тендерийн Багц-5-д оролцогч “Улаанбаатар аудит корпораци” ХХК-иас уг тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд холбогдох гомдлыг тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичиг, тайлбар тодруулгаас үзэхэд ТӨЗ 5.5-ийн 3-т “Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох 5 мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага”-ын шалгуур үзүүлэлтэд “Мэргэжлийн зэрэг, цол” гэсэн шаардлага тавьсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16.1-д “Тендерт оролцогчийн техникийн чадавхи, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараахь үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно” гэж, 16.1.1-т “Тендерт оролцогчийн удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар” гэж тус тус заасантай нийцэж байна.


Харин тендерийн баримт бичгийн ТӨЗ 5.5-ийн 3-т “Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх голлох 5 мэргэжилтнүүдэд “Тухайн чиглэлээр хийсэн судалгааны ажил, ном товхимол” гэсэн шалгуур үзүүлэлтийг заасан нь зөвлөх багийн бүх гишүүд тус шалгуурт нийцсэн байх, эсвэл багийн ахлагчид тус шалгуурыг тавьсан эсэх нь тодорхойгүй байна. Мөн танай яамнаас 2018 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 4/844 тоот албан бичгээр ирүүлсэн хариу тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд дээрх шалгуурыг ямар үндэслэлээр оруулсан талаар тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой..., хариуцлагатай байх зарчмыг баримтлана” гэж

заасныг зөрчиж тендерт оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т “Зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах” гэж заасны дагуу тендерийн баримт бичгийн техникийн саналд холбогдох өөрчлөлт оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдэж, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

Хувийг: “Улаанбаатар аудит корпораци” ХХК-д

ДАРГА  Б.ЛХАГВА

